

**ДЦУБ-аас Туркийн Анкара хотноо
2017 оны 11-р сарын 13-17-нд зохион байгуулсан
"Цаг уурын автомат станцын үйл ажиллагаа, суурилуулалт болон
засвар үйлчилгээ" сэдэвт олон улсын сургалтанд
хамрагдсан Ц.Баярмаагийн тайлан**

Улаанбаатар хот

2017.11.24

Цаг уурын автомат станцын үйл ажиллагаа, суурилуулалт болон засвар үйлчилгээ сэдэвт 5 дахь удаагийн сургалт нь Турк улсын Анкара хотноо Туркийн цаг уурын албанд зохион байгуулагдсан бөгөөд Туркийн цаг уурын албаны мэргэжилтнүүд болон Нигер, Синегал, Монгол, Хорват, Серби, Алжир зэрэг 7 улсын цаг уурын инженер, электроникийн инженерүүд оролцлоо.

Сургалтыг Туркийн цаг уурын албаны ажиглалтын системийн хэлтсийн дарга Эркин Буюукбас нээж үг хэлсэн бөгөөд цаг уурт хамгийн гол нь зөв ажиглалт, автомат станцын сайн алдаагүй эх мэдээг гаргах нь чухал ба эдгээр нь урьдчилсан мэдээ болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гол үндэс юм гэдгийг онцолсон.

Энэхүү сургалтаар Туркийн цаг уурын албаны ерөнхий танилцуулга, цаг уурын автомат станцын үйл ажиллагаа, засвар үйлчилгээ болон шалгалт тохируулга, цаг уурын мэдээ цуглуулах болон дамжуулах, өгөгдлийн чанарын хяналт, туркийн цаг уурын албаны сайтын <https://mgm.gov.tr/> хэрэглээний талаар хичээл орсон ба сургалтанд оролцогчдын албаны танилцуулга, автомат станцад үүсдэг ерөнхий бэрхшээл болон түүнийг хэрхэн шийдэж буй талаар харилцан туршлага судалсан ярилцлага, асуулт, хариулт хэлбэрээр өрнөсөн. Мөн өөрсдийн багаж тоног төхөөрөмжид хэрхэн шалгалт, тохируулга хийдэг талаараа ажлын байрандаа танилцуулга хийж шалгалтын тоног төхөөрөмжүүдээ танилцуулсан.

ДЦУБ-ын OSCAR сайтыг хариуцсан ажилтан Тимо онлайнар Женев хотоос холбогдож <https://oscar.wmo.int/surface/> сайтын талаар танилцуулсан. OSCAR-ыг Дэлхийн ажиглалтын хэрэгслүүд, тэдгээрийн судалгаа, олон улсын зохицуулалтыг хийх зорилгоор ДЦУБ-аас боловсруулсан юм байна.

Эцэст нь дүгнэхэд энэхүү сургалт нь хөтөлбөрийн дагуу сонирхол татахуйц хэлбэрээр явагдаж сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмж ажлын зохион байгуулалтыг өөр түвшнээс харсан, олон талын ач холбогдолтой мэдээ, мэдээлэл өгсөн үр дүнтэй сургалт болсон.

Цаашид хэрэгжүүлэх ажлын санал:

1. ЦУОШГ-ын харъяа байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, ашиглаж буй техник, багаж, тоног төхөөрөмжтэй цаг уурын салбарт ажилладаг хүмүүс танилцаж, салбар, салбарын ололт амжилт цаашдын сайжруулалтын талаар санаа оноогоо хуваалцдаг, харилцан туршлага судалдаг байвал ололттой санагдсан.

2. Буянт-Ухаа станцын инженерүүдэд сургалт

Энэхүү сургалтад оролцох боломж олгосон ЦУОШГ болон НЦУТ-ийн холбогдох албан тушаалтнуудад талархал илэрхийлье.

Тайлан бичсэн: Нислэгийн цаг уурын төвийн
инженер Ц.Баярмаа



